

2025 он 12 сарын 16 өдөр

Дугаар 25/14

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийх зовшоорол олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр зүйл, 76.1.16, 76.1.17 дахь заалт, “Хөвсгөл” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 12 сарын 16-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-аас нийт гаргасан энгийн хувьцааны 7 хувьтай тэнцэх өөрийн хувьцааг буюу 2,000,000 ширхэг хувьцааг, нэг бүрийн үнэ 4,000 (дөрвөн мянга) төгрөгөөр тооцож худалдан авахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Ард Лизинг ХХК-аас нэг бүрийг 50 (тавин) төгрөгөөр тооцож, 10 тэрбум төгрөг хүртэлх Ардкойн худалдан авахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ, баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА  П.БАТБАЯР